



**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

**Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн
баталгааг хангах хөтөлбөр
батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.8 дахь заалт, 43 дугаар зүйл 43.1.7 дахь заалт, Үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйл 6.8 дахь хэсэг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч захирагч “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын даргатай байгуулсан Хариуцлагын гэрээний 2 дугаар зүйл 2.1.12 дахь заалт, Хамтын гэрээний 6 дугаар зүйл 6.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйл 3.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс (П.Алтантөгс)-д үүрэг болгосугай.

3.Хөтөлбөр хэрэгжихтэй холбогдон гарах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэхийг Санхүү бүртгэлийн хэлтэс (Б.Баярцэцэг)-т звшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн дарга (Б.Ганболд)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Үйлдвэрийн газрын 2022 оны А/57 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



О.ГАНБААТАР